

Орон бүхний пролетариат нар нэгдэгтүн! АНХ ДУГААР ТАВАН ЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, А.Д.Х-ын гүйцэтгэх захиргааны сонин

26 дахь
жилдээ

№ 33 (2297)

1974 оны 4 дүгээр сарын 29

ДАВАА

УРИН ЦАГ—ИХ БАРИЛГА

Аймгийн Барилга угсралтын конторын хамт олон социалист уралдааныг эрчимтэй өрнүүлэн ажилласны үр дүнд 1973 онд урьд оноос 1 сая төгрөгийн барилга угсралтын ажил илүү гүйцэтгэж жилийн төлөвлөгөөг 116,3 хувиар биелүүллээ. Мөн хөдөө аж ахуйн барилга байгууламж, малын хашаа барих, худал гаргах төлөвлөгөө 103,2—113,3 хувиар биелэсэн байна.

Аймгийн барилгачид 1974 оны төлөвлөгөөг 11 дүгээр сарын 15-ны дотор ханган биелүүлэхээр социалист уралдаанд үүрэг авч ажиллан конторын хэмжээгээр 1974 оны 1 улирлын барилга угсралтын төлөвлөгөөг 110,8 хувиар биелүүлж жилийн төлөвлөгөөний 18 хувийг гүйцэтгээд байна.

Тус контор барилгын үйлдвэрлэлд аж ахуйн тооцоот нэгдсэн бригадыг байгуулж ажилласнаар барилга барих хугацааг 27—54 хувиар богиносгож, хөдөлмөр зохион байгуулалт, эдийн засгийн чанарын үзүүлэлтийг дээшлүүлэхэд нөлөөлөхүйц ажлын дэвшилт арга хэлбэрийг хэрэглэж байгаа нь ийнхүү амжилт олохын үндэс болж байна. Нэгдэл, САА-нуудад 10—25 хүнтэй барилгын нэгдсэн бригадууд ажиллаж малын хашаа барих, худал гаргах, засварлах ажлыг гүйцэтгэж байна.

Гэвч САА-н барилгын бригадууд жилийн эхнээс жигд ажиллахгүй нөгөө талаас сумын нам, захиргааны байгууллагын барилгын ажилд тавих хяналт шалгалт сулаас улирлын байдлаар ажиллаж, барилгын мэргэжилтэй ажилчдаар дутагдалтай зэргээс малын хашаа барих, засварлах амлаас хэтрэхгүй байна.

Ийм байдлаас болж оны эхэнд тайвширч санаа амирлангүй сууж байгаад цаг хугацаа алдаж төлөвлөгөө таслах буюу улирал, жилийн эцэс рүү довтолгож барилгын чанаргүй барих, хөдөлмөр материал, санхүүгийн илүү гарздал гаргахад хүрч байна.

Одоо аймгийн хэмжээгээр хашаа барилт 10,1 хувьтай байгаагаас гадна Баян, Баяндэлгэр, Бүрэн, Баянцогт сумд хашааны материалаа ч татаагүй, цагийн дулаан, өнгөрсөн оны амжилтандаа тайвширч байна.

Иймд барилгын байгууллагууд үйлдвэрлэлийн хэвийн ажиллагааг хангах бүхий л арга хэмжээг гурдчилан авч сар тутмын төлөвлөгөөг нэр төрдөөр нь чанартай жигд биелүүлэх, урин дулааны улиралд ихийг хийж бүтээхийн тулд ажлын цаг, машин техникийн хүчин чадлын ашиглалтыг улам сайжруулах, график төлөвлөгөөг нарийн мөрдөхөд барилгын захиргаа, нам, олон нийтийн байгууллага байнга анхаарал тавьж ажиллах нь чухал юм.

Их барилгын үйлдвэрлэлийн бүхий л амжилт ололт нь барилга, зураг төсөв, захиалагч байгууллагын нягт хамтын ажиллагаанаас шууд шалтгаалдаг учир эдгээр байгууллагын хоорондын ажил төрлийн уялдаа холбоог улам сайжруулж тус тусынхаа хүлээсэн үүргийг цаг тухайд нь биелүүлэх, үүрэг хариуцлагыг өндөржүүлэх нь үйлдвэрлэлийн жигд ажиллагаанд төдийгүй хөрөнгө оруулалтын үр дүнг дээшлүүлэхэд чухал түлхэц болно.

Барилгын үйлдвэрлэлийн дэргэдэх намын байгууллага, олон нийтийн болон ардын хяналтын бусад байгууллагатай хамтарч үйлдвэрлэлийн жинхэнэ явц, чанар, машин техникийн ашиглалт, материал хангамж, хүмүүсийн цаг ашиглалт, ажлын хариуцлагад үе үе шалгалт хийж, дүнгийн нь хамт олны хурлаар хэлэлцүүлж, сайн амжилтыг бататган, саар дутагдлыг арилгах арга хэмжээ авч байх хэрэгтэй.

Барилгын үйлдвэрлэлийн жигд ажиллагааны нэг үндэс болсон материал хангамж муугаас материалаар тасалдан сул зогсох зэргээр дуусаагүй барилгын тоог олшруулан, хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулах дутагдал байгааг давтаж болохгүй.

Урин цагт барилгын ажлын голыг амжуулахад чухалчлан анхаарч эхний хагас жилд барилгын жилийн төлөвлөгөөний 60-аас доошгүй хувийг гүйцэтгэсэн байх, социалист уралдааныг барилгачдын дунд эрчимжүүлэн сарын төлөвлөгөөний дутууг дараа сард нь 1 улирлын дутууг 11 улиралд, жилийн төлөвлөгөөг хугацааны нь өмнө биелүүлэх зорилтыг хэрэгжүүлбэ.

КОММУНИСТ СУББОТНИКООР

■Баянцагаан сумын төвийн нийт албан хаагчид коммунист субботникоор бод малын хашааны чулуу кублэж газар дээр нь татаж буулгаад 36 шоо метр хана өрөв. Мөн ХБ ангийн давсалгааны байрны барилгын чулуу бэлтгэж 12 метр урт, 6 метр өргөн барилгын суурь барьжээ. Энэ ажилд Х.Довдончулуун, Сосорбарам даргатай сумын клуб, ХБ ангийн хамт олон бусдаасаа илүү сайн ажиллаж нийтдээ 3000 төгрөгийн барилгын ажил хийжээ.

■Баян сумын 8 жилийн дунд сургуулийн багш сурагчид коммунист субботникийн өдөр хүүхдийн төлөө фондоод 2000 шахам төгрөгийн орлого оруулав. И.ЦЭДЭНДАШ

Таван жилийн төлөвлөгөөний тэргүүн эгнээнд хошуучлагчдад баяр хүргэе!



ЗУРАГ ДЭЭР: (Зүүн гараас) V таван жилийн төлөвлөгөөг 2 жилээс 2 жил 6 сарын өмнө биелүүлсэн гавшгайч 13 дугаар баазын жолооч Ө.Шагдар, НААУ-ийн газрын оёдолчин Р.Ичинхорлоо, холбооны газрын ялагч Ш.Цэрэнханда.

Л.ДАМДИНДОРЖ-ийн авсан гэрэл зураг

БАРИЛГАЧДЫН АМЖИЛТ

Аймгийн Барилга угсралтын контор социалист уралдааныг эрчимжүүлэх талаар зарим ахиц олж тэмдэглэлт баяр, ой угтсан ажлын өндөр бүтээлийн болзол зарлан дүгнэх, бригадуудыг оноот уралдаанаар ажлын цаг ашиглалт, норм төлөвлөгөөний биелэлт, бүтээгдэхүүний чанар зэргээ үзүүлэлтээр бэллээр байр эзлүүлэх "Гойрон аялалд хэн оролцох вэ?" гэсэн болзолт уралдааныг зохион байгуулж байна.

Барилга угсралтын ажил өнгөрсөн оны мөн үеийнхээс 164,2 мянган төгрөгөөр давуу байна.

Одоо тус конторын Жалбаа даргатай Залуучуудын нэрэмжит нэгдсэн 3 дугаар бригадын хамт олон аймгийн ҮЭ-ийн 17 дугаар бага хурал угтаж бригадын чанарын аварга өрлөгчин шалгаруулах 5 хоногийн болзолт уралдаан зарлажээ. Энэ уралдаанд барилгачин н. Пүрэвжав 27,8 кубметр өрлөг хийж I байр, II, III байрыг Б.Мягмардаш, Ш.Дашвал нар эзэлж болзлын хугацаанд 52,5 кубметр өрлөг өрөх байсныг 86,7 кубметр өрлөг өрж болзлыг 65 хувиар давуулжээ.

Аймгийн 5 удаагийн аварга барилгачин, намын гишүүн Д.Намсрай 1974 онд 25,8 мянган төгрөгийн ажил хийх юм.

Тэрээр өөрийн нормоос 655 төгрөгийн ажил буюу барилга угсралтын ажилд зарцуулах хүн цагийг 2000-д хүргэх үүрэг аваад ажиллаж байна.

Мөн аймгийн аварга барилгачин, намын гишүүн Д.Бор 5 жилийнхээ ажлыг 3 жил 3 сард биелүүлж 131,1 мянган төгрөгийн ажил гүйцэтгэсэн ба удирдсан бригад нь 4 жил 2 сарын ажлыг хийгээд байна.

Ц.МАЖИГСҮРЭН

Хорин гурван салаа

Угтаалын САА-н захиргаа, ХЗЭ-ийн хорооноос тэргүүний тариаланчдын улсын зөвлөлдөөнөөс гаргасан уриалгыг биелүүлэх 2 жилийн ажлын төлөвлөгөө гаргаж, нийт тасаг, бригадууд тариаланчдын хурал цуглаанаар хүлээн авч сурталчлах ажлыг өргөн зохиож байна.

Тариаланчдын 5 жилийн төлөвлөгөөний эхний 3 жилийн ажлыг хүн тус бүрээр тооцоолоод үлдэж буй 2 жилд хичнээн хэмжээний ажил хийх талаар тооцоотой үүрэг авахуулав.

Энэ үндсэн дээр нийт тасаг, бригадуудыг 100 хувь хамарсан механикчсан салаа 23-ыг шинээр байгуулж тэдэнд хүн хүч, эзэмших техник, хариуцах талбайг 5 жилийн хугацаагаар эзэмшүүлж ажиллуулахаар өгөв.

Д.СУМБЯА

Төл бойжилтын явц

Аймгийн хэмжээгээр 4 дүгээр сарын 22-ны байдлаар төлөвлөх зохих эх малын 70,2 хувь буюу 445,2 мянга нь төлөж гарсан төлийн 99,0 хувь нь буюу 445,3 мянга нь бойжиж байна.

Төл бойжилтыг сумдаар байр эзлүүлбэл:

Сумдын нэрс	Бойжилтын хувь	Эзлэх байр
Баянцагаан	100,0	1
Эрдэнэсант	99,9	2
Баян-өнжүүл	99,8	3
Баян	99,8	4
Угтаал	99,8	5
Баянцогт	99,8	6
Алтанбулаг	99,7	7
Лүн	99,7	8
Өндөрширээт	99,7	9
Баянжаргалан	99,7	10
Сэргэлэн	99,5	11
Дэлгэрхаан	99,4	12
Баянчандмань	99,4	13
Мөнгөнморьт	99,3	14
Баянзүрх	99,2	15
Борнуур	98,9	16
Батсүмбэр	97,8	17
Эрдэнэ	97,7	18
Бүрэн	97,4	19
Заамар	96,8	20
Жаргалант	96,4	21
Баяндэлгэр	96,1	22

Статистикийн товчоо

МХЗЭ-ийн анхан шатны үүр, хороодын нарийн бичгийн дарга нарын зөвлөлгөөний өмнө

БАРИАНД ОЙРТОЖ ЯВАА ХОРОО

Зуунмод хотын ХЗЭ-ийн хороо, МХЗЭ-ийн анхан шатны үүр, хороодын нарийн бичгийн дарга нарын улсын анхдугаар зөвлөлгөөнийг угтаж ажлын тодорхой чиглэл боловсруулан ажиллаж байна.

ХЗУ-ын комиссолын байгууллагын туршлагаар ХЗЭ-ийн үүрийн дарга нарыг оролцуулж идэвхтний сургуулийн долоо хоног бүрийн Пүрэв гаригт хичээллүүлж үүгээр «Эвлэлийн ажлын төлөвлөлт», «Бүх гишүүдийн хурал хийх аргачлал», «Эвлэлийн ажилтны үүрэг хариуцлага», «Гишүүдийн манлайллыг дүгнэх тухай» зэрэг сэдвээр сүүлийн нэг жил хагаст 82 цагийн хичээл заажээ. Мөн ажлын төлөвлөлтийг сайжруулъя гэсэн сонин бага хурлын дагуу эвлэлийн сонгуультай ярилцлага зохиож, үүр тус бүр жилийн ажлын төлөвлөгөөг энэ дагуу хийлгэжээ.

Ажилчин залуучуудын дунд мэргэжлийн уралдаан, чанарын өдөрлөг, өндөр бүтээлийн уралдааныг зохиож, ажиллуулснаар 1973 онд 240 ажилчин залуучууд төлөвлөгөөг хугацаанаас нь 20-30 хоногийн өмнө давуулан биелүүлж хотын ХЗЭ-ийн гишүүдийн дотроос хивсчин Д. Долгоржав, тогтооч Б. Эрдэнэсүрэн, хүмүүжүүлэгч Н. Оюун нар аймгийн хөдөлмөрийн аварга болж, Д. Дашдулам, Рина, Жаргалмаа нар МХЗЭ-ийн Говь Хорооны «Тэргүүний ажилчин залуу» алтан медалиар шагнагдав.

ХЗЭ-ийн үүрийн идэвхтэн сонгуультад тусламж болгож, эвлэлийн идэвхтэн, гишүүдийн даалгавар өгөх чиглэл, ги-

шүүдийн манлайллыг оноогоор дүгнэх удирдамж, бүх гишүүдийн хурлын жилийн төлөвлөгөөний үлгэрчилсэн аргачлал зэргийг боловсруулан өгч эвлэлийн анхан шатны байгууллагат заавал мөрдөж байх тэргүүн туршлагын жагсаалт, улсын зөвлөлгөөн угтаж хэвшил болгох 12 зүйлийг гарган өгч биелэлтийг сар бүрийн эцэст хотын ХЗЭ-ийн хорооны товчооны гишүүд шалгаж үүрүүдийн ажлыг онцот уралдаанаар дүгнэж байна.

Мөн залуу үеийг ахмадын хувьсгалч дайчин хөдөлмөрч уламжлалаар хүмүүжүүлэхийн тулд цуврал уулзалтууд зохиожээ.

Сүүлийн 4 жилд залуучуудын лекцийг төрөлжүүлэн хийж энэ онд 400 гаруй залуучуудаас ямар лекц уншуулах хүсэлтэй байгаа талаар судалж, энэ дагуу лекцийг чанаржуулж байна.

Үүний үрээр лекцийн агуулга, хэлбэр улам сайжирч, аман сэтгүүл, үзүүлэлт лекц, кино лекц уралд бүр явууллагаас гадна хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтнүүд, эрдэмтэдтэй уулзалт зохиож байгаа нь залуучуудын хүсэл сонирхолд нийцэн тэдний лекцэнд очих хүсэлтийг өрнүүлж байна.

Дээрх ажлуудыг зохиож ирсний үр дүнд эвлэлийн анхан шатны байгууллагын ажилд ашиг гарч 1972 онд тус ХЗЭ-ийн хороо аймагтаа 28 дугаар байр эзэлж байсан бол 1973 онд 6 дугаар байранд орж одоо анхан шатны байгууллагынхаа дотоод ажлыг тогтмолжуулах зорилт тавиад ажиллаж байна.

Г. БЯМБА-РИНЧИН

МАЛ ТАРГАЛУУЛАХ ЧУХАЛ ЗОРИЛТ

(ЗОО-ЭДИЙН ЗАСГИЙН БАГА ХУРАЛ)

Малыг отор бэлчээрээр таргалуулах тухай зоо-эдийн засгийн бага хурлыг аймгийн Намын хорооны үзэл суртлын хэлтэс ХАА-УГ-аас эрхлэн хийлгэв.

Тус бага хурлаар «Мал таргалуулалт оторлолтын 1973 оны дүн, цаашид тавих зорилтын тухай» хэлэлцэв.

Хэлэлцсэн асуудалтай холбогдуулж Жаргалант, Баяндэлгэр, Баян-өнжүүл сумдын зоо-техникч Цэрэнпэл, Д. Санжаа, Төмөрбаатар, аймгийн АХШ хорооны дарга Р. Чимэдцэрэн, Алтанбулаг сумын УЗХС-ын дарга Доржсүрэн нар үг хэлэв.

Хуралд тавьсан илтгэлээс үзэхэд өнгөрсөн онд 1 сая 35 мянган мал оторт гарч отрын хугацаанд мал сүргийнхээ 96,6 хувьд нь дунд ба дундаас дээш тарга хүч авахуулжээ.

Малаа сайн таргалуулсан малчдын тарга хүчний нэмэгдэл хөлсөнд 32,7 мянган төгрөг зарцуулжээ.

Өнгөрсөн онд Баян-өнжүүл, Луи, Баянцогт, Заамар, Алтанбулаг зэрэг 10 гаруй сумдын 27 бригад, 206 суурь, 763 өрх, 1200 гаруй малчид 36 хэсэгт өргөн айлсат хийжээ.

Өргөн айлсалтынхан өөрсдийн хүчээр 51 тонн байгалийн хадлан, 12 тонн гар тэжээл бэлтгэн 27 гарын мод засварлан, 480 гаруй үнээ, 15 мянган хонь саажээ.

Итгэгч болон үг хэлсэн хүмүүсийн саяа дүгнэлтээс үзвэл өнөө цагийн шилт малын махны нөөцийг нэмэгдүүлэхэд хээлтүүлгийн үзэс эхлэн анхаарч хээлтэгч, хээлтүүлэгч малыг нийлүүлэхдээ тохируулан сонгож элсэв буюу 1 дүгээр ангийн хээлтэгчийг элзийн рекорд буюу элзийн ан-

гийг хээлтүүлэгчээр, 2, 3 дугаар ангийн хээлтэгчийг заавал элзийн буюу 1 дүгээр ангийн хээлтүүлэгчээр хээлтүүлбэл гарсан төл нь эцэг ба эх малаасаа илүү сайн байдаг байна.

Гарсан төлийг эхийн уураг сүүгээр эхийн 7-14 хоногт цадтал нь тогтмол хөхүүлж махлуулах, 14 хоногоос нь хойш борог тэжээл, ус эрдэсийн тэгжээлд дасган ногоотой залгах хүртэл (5 дугаар сарын 15), чанар сайнхны витаминг өвс, хивэг, багсармал, эрдэсийн тэжээлийг хүрэлцэхүйцээр өгч байнга усалж байх нь төлийн хорогдол гаргахгүй байх үндсэн боломжийг бүрдүүлдэг байна.

Эр сувай, бэлтгэлийн насны малыг хаавар эрт (4 дүгээр сарын сүүлч, 5 дугаар сарын эхээр) соргог сэрмүүн, ногоо эрт гардаг нутгаар оторлон махлуулж, хүч тарга муутай бэлтгэлийн малыг 5 дугаар сарын 1-нээс эхлэн ялгаж, тэжээж бордон урьд жилүүдийн аймгийн дунджаас үхрийг 5 кг, хонь ямааг 3 кг-аар тус тус нэмэгдүүлэх зорилт тавьж байгааг илтгэгчид цолон тэмдэглэв.

Бүх малд 5 дугаар са-

рын 25-ны дотор зоо-мал эмнэлгийн хаврын үзлэг заазлалт явуулж, зааз ба өвчтэй малыг тусгайлан суурьж тэргүүний малчдад хариуцуулан оторт гаргах нь чухал.

Өргөн айлсалтыг Бригад бүрт зохион байгуулахын хамт сүүний тасгууд 6 дугаар сарын 1-нээс 9 дүгээр сарын 15 хүртэл хугацаанд 4-өөс доошгүй удаа нутаг сэлгэн үнээ тугалдаа тарга хүч авахуулах, түүнээс хойш үнээг саалинаас чөлөөлөх нь үнэнд тарга хүч авахуулах боломжийг өгөх юм.

Гүүг саалинд ашиглахдаа азарга азаргаар нь 100 орчмоор ээлжлэн сааж 10 дугаар сарын 1 гэхэд саалинаас бүрэн чөлөөлж өвлийн оторт гаргах, малыг шөнийн сэрүүнд идэшлүүлэх нь бэлчээрээр таргалуулах аргыг сайжруулах, мал бэлчээрлэх цагийг уртасгах гол арга мөн.

Бага хуралд аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга Ц. Жамсран оролцож мал таргалуулалтын ач холбогдол, отор нүүдэл, өргөн айлсат хийх аргын талаар үнэтэй зөвлөлтөө өгөв.

МАНЭЙ СУРВАЛЖЛАГЧ



Таван жилийн төлөвлөгөөг 2 жилийн өмнө биелүүдсэн аймгийн Холбооны шуудан хүргэгч Д. Нямсүрэн ажил дээрээ.

АВЬЯАС БИЛГЭЭРЭЭ ТОДРОН ШАЛГАРЬЯ

МАХН-ын III их хурал, БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ойг угтаж орон даяар сайн дурын уран сайханчдын урлагийн үзлэг явуулах тухай МАХН-ын Товчооны Улс төрийн Товчооноос саяхан гаргасан тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн Намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас тогтоол гаргав.

Уг тогтоолоор сайн дурын уран сайханчдын урлагийн үзлэгийг зохион байгуулах аймаг, сумын комисс байгуулж ардын урлагийн дэвшилт уламжлалаас суралцаан авьяастан олны эгнээг өргөтгөхөд чиглүүлж аймгийн нийт сайн дурын уран сайханчдын гурван шатны үзлэгийг бэлтгэл зохион байгуулалт сайтайгаар

1974 оны 2 дугаар улиралд багтаан явуулахаар шийдвэрлэсэн юм.

Үзлэгт албан үйлдвэр, ХАА, соёл, 8 дугаар ангиас дээш ангийн сурагчид, техникум, тусгай мэргэжлийн болон их дээд сургуулийн оюутан, сурагчид оролцоно.

Үзлэгт мэргэжлийн урлагийн байгууллага оролцохгүй бөгөөд сайн дурын уран сайханчдын бүсийн үзлэг 6 дугаар сарын 11-нд Дорноговь, Архангай, Булган, Ховд аймгуудад явагдана.

Манай аймаг Архангай аймагт болох бүсийн үзлэгт бэлтгэн, аймаг, хотын хэмжээнд явагдсан урлагийн үзлэгээс уран авьяас билгээрээ тодорч шалгарсан 20 хүнийг бү-

сийн үзлэгт оролцуулах юм.

Үзлэгт ардын урт, богинын, мөн зохиолын дуу дуулаачид, ардын төрөл бүрийн хөгжимтэй, баян хуураар тоглогчид, бүжигчид, уран уншигч нар оролцоно.

Дуулаачид нь урт богинын болон зохиолын дуугаар гоцлол, хоршил, харилцаа гурвал, дөрвөл хүртлэх бүрэлдэхүүнээр орох ба дөрвөөс дээш бүрэлдэхүүнээр оролцохгүй.

Дуучид нь ур чадвар хоолойн царцаа чадал шаардах бүтээлийг сонгон авч дуулна.

Үзлэгт оролцох дуучид 2 дуу дуулах бөгөөд 1 дүгээр дууг өөрөө шилж авах ба 2 дугаар дуу нь зааварт нэр заагдсан дуу байна.

Хөгжимчид нь гоцлоос тавал хүртэл хуур, ятга, хуучир, шанз, ёочин, их хуур, цохивор хөгжим, ардын үлээвэр, хулсан аман хуур, домбоор ховоз, цуур баян хуур зэрэг хөгжмийн зэмсэгтэйгээр зааварт заагдсан зохиолыг тоглож, бүжигчид нь гоцлол, хоршил, дөрвөл хүртэл бүрэлдэхүүнээр оролцоно.

Уран уншигчид сэтгэлгээг хэллэг хоолойн өнгө, ур чадварыг гаргахаар бүтээлийг сонгон авахаас гадна зааварт заагдсан зүйлээс заавал уншина.

Сайн дурын уран сайханчдын бүтээлийн агуулга нь орчин үеэ тод дүрсэлж шинэ хүнийг төлөвшүүлэн хүмүүжүүлэх, хөдөлмөр ахуйд соёл нэвтрүүлэх, урлагийн төрөл хэлбэрийг бүтээлчээр эзэмших, урлах эрдэм

авьяасыг хөгжүүлэхэд чиглэгдсэн байх ёстой.

Одоо их ой угтсан урлагийн 1 дүгээр шатны үзлэгийг Жаргалант, Баянзүрх, Баянагаан, Баян-өнжүүд, Баянцогт, Эрдэнэ зэрэг сумууд амжилттай явуулж аймгийн үзлэгт бэлтгэж байна.

Манай социалист урлагийн үндэс шинэ тэжээл болсон ардын урлагийн өв санг нээн аранжуулах, ардын урлагийн ховор нандин бүтээлийг тодруулах, шинэ залуу авьяастны авьяас билгийг тодруулах хөгжүүлэх явдал бүх ард түмний сайн дурын уран сайханчдын үзлэгийн гол зорилт мөн.

Иймд нийт сум-нэгдэл, САА, үйлдвэр, албан байгууллагууд урлагийн үзлэгт эртнээс чанар сайтай бэлтгэх хэрэгтэй байна.

Н. СОДНОМХҮҮ



Социалист уралдаан, төл бойжилт

Баянпаган сумын нам, захиргаа, 1974 оны бүх ард түмний социалист уралдааны жилд оны эхнээс эхлэн малчид хөдөлмөрчдийн идэвх хөдөлгөөнийг өрнүүлэх талаар нээл ажил зохиож байна. Оны эхэнд хөдөлмөрийн аваргуудын зөвлөлгөөний хийж ажлын нь арга туршлагыг харилцан ярилцуулж нийт хүмүүсийг социалист уралдаанд уриалж үүрэг амлалт авахуулан юм.

Мөн зарим малчидтай социалист уралдааны гэрээ байгуулан, 5 хушуу малын төл бойжилт тус бүрт, мөн ихэр төлийн болзууд гаргах төлийг бригадуудын штабууд 10 хоног тус дүгнэн сууриудыг цуваагаар байр эзлүүлж түрүүлэгчдийг шагнаж урамшуулж байна. Уралдааны эдгээр арга хэлбэрийг хэрэглэн ажилласны дүнд сумын дүнгээр төлөх бөгөөд малын 80 гаруй хувь нь буюу 32 гаруй мянган мал төлөж төлөө 100 хувь бойжуулж байна.

Тухайлбал малаж ахуйн 4 бригад 120 суурь төлийн хорогдолгүй байгаагийн дотор «Алтан» бригадын хоньчин улсын аварга малчин Ж. Хүрэл, хоньчин Ж. Жүрмэд, Ж. Очир, С. Банзрагч, «Баян-айраг» бригадын хоньчин Я. Дэндэв, намын гишүүн н. Цэвэрэгзэн, энх сүрэгтэн Д. Очир, Гурвантүрүү» бригадын Х. Минжүүр, намын гишүүн С. Дамдинсүрэн, улсын аварга малчин Б. Гонгор, Бат, «Өлзийт» бригадын А. Дамдинсүрэн нарын олон арван малчид 100 эхээс 102—108 төл бойжуулж 20—40 ихэртэй байна.

Бригадуудыг 1 дүгээр улирлын ажил, төл бойжилт зүй бус хорогдол

зэргийг харгалзан социалист уралдаанд шалгаруулан дүгнэхэд «Алтан» бригад 1 дүгээр байр эзлэж «Баян-айраг», «Гурвантүрүү», «Өлзийт» бригадууд удаах байранд явна.

Том малын зүй бус хорогдолтой тэмцэх талаар нэгдлийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж төлөвлөгөө зохион, сум бригадаар урьдах 3 жилийн дундаж хорогдлыг 60,5—69 хувиар багасгах тооцоо хийж, тэжээл эмчилгээний цэгийн ажиллагаа, малын ширцлэаг малаагаа сайжруулан ажилласнаар одоогийн байдлаар өнгөрсөн оны энэ үеийн хорогдлыг 5 дахин багасгаад байна.

Тус суманд улсын аварга малчин 4, аймгийн аварга 71 байгаагаас 1973 онд тус бүр нэг хүн улс, аймгийн аварга малчин болсон юм.

Манай сумын бүтээлч хөдөлмөрчид малчид МАХН-ын III их хурал, БНМАУ-ыг тунхагласны болон өөрийн сум байгуулагдсаны 50 жилийн ойнуудыг ажлын өндөр амжилтаар угтахаар ийнхүү зориг дүүрэн ажиллаж байна.

Сумын намын үүрийн нарийн бичгийн дарга Б. ЛХАМ

Малчдын нөр хөдөлмөрийн үр дүн

Хошуучилж явна

Алтанбулаг сумын «Жаргалант» бригадын хоньчин А. Найдан 520 эм хониноос 520 хурга, 35 ямаанаас 35 ишиг Н. Самбууян 574 хониноос 574 хурга, 55 ямаанаас 58 ишиг, О. Пүрэвдорж 60 ямаанаас 61 ишиг, Рэнцэндорж 73 ямаанаас 79 ишиг хүлээн авч нэг ч төлийн хорогдолгүй социалист уралдаанд хошуучилж явна.

Л. ДОЛГОР

Талчид шалгаруулав

Бүрэн сумын Бүрэлдэлгэрэх нэгдлийн «Хайрхан» бригад төл бойжилтын дүнг цуваагаар байр эзлүүлэн дүгнэж 320 эм хониноос 323 хурга, 45 ямаанаас 50 ишиг бойжуулсан аймгийн АХ-ын депутат Баярын суурийг 1 дүгээр байр, 363 эм хониноос 364 хурга, 24 эм ямаанаас 25 ишиг бойжуулсан намын гишүүн Павгаанайдагийн суурийг 2 дугаар байр, төлөө 100 хувиар бойжуулсан О. Тантан Ц. Цэдэндамба нарын сууриудыг 3 дугаар байр эзлүүлэн шалгаруулав.

Мөн бригадын хоньчин Д. Цэрэндэмбэрэлийн харлаг хониноос гарсан 3 ихэр хурганд ихэр төлийн гэрчилгээ мөнгөн шагнал олгов.

З. ПУНЦАГЦЭРЭН

ТӨЛ БҮРЭН

Алтанбулаг сумын «Хөдөлмөр» нэгдлийн Алтановоо бригадын хоньчин А. Дорж 338 хониноос 342 хурга, 41 ямаанаас 55

ишиг, Г. Нямдоо 117 хониноос 117 хурга, 210 ямаанаас 224 ишиг, Ч. Цэрэндорж 541 хониноос 540 хурга, 61 ямаанаас 68 ишиг тус тус хорогдолгүй бойжуулж байна.

Н. СОДОВ

Хөдөлмөрчдийн хууль ЗҮЙН МЭДЛЭГТ

ГЭМТ ХЭРГИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

Аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны зохион зааварлах хэлтэс, «Анхдугаар таван жил» сонинны редакци хамтран энэ дугаараас эхлэн «Хөдөлмөрчдийн хууль зүйн мэдлэгт» зориулалт бүтэцтэй бичнэ.

Энэ бүтэцтэй БНМАУ-ын үндсэн хууль, эрх зүйн хууль зүйн холбогдолтой бусад хууль тогтоомжуудыг хялбарчлан тайлбарлах учир нийтлэгдсэн материалыг гүнзгий судлан, тодруулах зүйлээ сонинны редакцид ирүүлэн хариу авч байхыг хүсье.

Гэмт хэрэг бол нийгмийн үзэгдэл бөгөөд хүний нийгмийн хөгжлийн тодорхой шатанд үүссэн, мөн тодорхой шатанд устах учиртай.

Манай оронд эрүүгийн гэмт хэрэг үүсэн гарах нийгэм эдийн засгийн үндэс устсанаар эрүүгийн гэмт хэргийн төрөл, гаралт эрс хорогдсоор байна. БНМАУ-ын нийгмийн ба төрийн байгууламж, бодон социалист хэв журамд аюултай, тус улсын эрүүгийн хуулийг зөрчсөн, гэм буруутай ял шийтгэлтэй, зөвхөн эрүүгийн хуульд тодорхойлсон идэвхтэй ба идэвхгүй үйл ажиллагааг эрүүгийн гэмт хэрэг гэдэг.

Идэвхтэй ажиллагаа гэдэг нь эрүүгийн хуульд хориглосон хэм хэмжээг зөрчсөн үйлдэл (социалист эмчийг ашиглах зэвсгийг хориглосон) идэвхгүй ажиллагаа гэдэг нь эрүүгийн хуульд тодорхой үүрэг гүйцэтгэхийг шаардсан үйлдэл өвчтэй хүнд тусламж үзүүлэх,

—Гэмт хэрэг нь заавал гэм буруутай байна.

—Уг үйлдэл нь эрүүгийн хуульд заасан ял шийтгэлтэй байна.

Үйлдсэн нэгэн гэмт хэргийн дотор гол шинж бүрэн байснаар эрүүгийн гэмт хэрэг мөн гэдгийг тогтооно. Дээрхи шинжийн аль нэг нь байхгүй бол гэмт хэрэг биш.

Гэмт хэрэг нь гэмт хэргийн объект, объектын тал, субъект, субъектын тал гэсэн өөртөө тодорхой бүрэлдэхүүнтэй байдаг. БНМАУ-ын эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 6 дугаар зүйлд: болсон үйл явдал гэмт хэргийн бүрэлдэхүүн байхгүй бол эрүүгийн хэргийг үүсгэн

явуулж, болохгүй, хэрэг эрүүгийн хэрэг үүсгэсэн байвал хэрэгсэхгүй болгоно гэсэн заалт бий.

Үүнээс үзэхэд гэмт хэргийн бүрэлдэхүүний тухай асуудал практикийн их ач холбогдолтой нь илэрхий юм.

Гэмт хэргийн бүрэлдэхүүнийг тус бүрд нь хэргийн товч угтаар тайлбарлавал:

—Гэмт хэргийн объект гэдэг нь гэмт хэрэг чухам юунд чиглэснийг харуулах ба гэмт халдлагаас эрүүгийн хуулиар хамгаалагдаж байгаа социалист нийгмийн харилцаа юм.

—Хүмүүсийн нийгэмд аюултай үйл ажиллагаа

ба учирсан хор хөнөөл хоёрын холбоо, гэмт хэрэг үйлдсэн газар, цаг үйлдлийн арга нь гэмт хэргийн бүрэлдэхүүний объект талын шинж болно.

—Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн тэр гэмт хэрэгтээ эрүүгийн хариуцлага хүлээх чадвартай хүнийг гэмт хэргийн субъект гэнэ.

—Гэмт хэргийн субъектив тал гэдэг нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн сэтгэхүйн харьцааны илрэл мөн.

Гэмт хэргийн бүрэлдэхүүн нь тодорхой төрлийн гэмт хэрэг нэг бүрд харилцан адилгүй шинжийг хадгалах учиртайг бололцоол зохино.

Б. ЖУНАЙ

Анги дэвших ба төгсөх улсын шалгалтын өмнө

ОНЦ СУРЛАГАТНУУДЫН ЯРИЛЦЛАГА

Жаргалантын САА-н 10 жилийн дунд сургуулиас онц сурлагатан сурагчдын туршлага солилцох дугуй ширээний яриа хийв.

Уг ярианд оролцсон 10-ын «А» ангийн сурагч онц сурлагатан Нармандах ярихдаа: Би 39 улирал дараалан онц сурлаа.

Би өдөрт хичээлээ нарийн цагийн хуваарьтай давтаж хичээлэх гадуур давтлагын журмаар хичээлтэй холбогдох нэмэлт зохицуулдгт уншиж тэмдэглэл хөтөлдөг бөгөөд ангийн бусад сурагчдын хамт ярилцаж давтдаг гэж ярихад 9-ийн «Б» ангийн онц сурлагатан, МПБ-ын Төв Зөвлөлийн

мөнгөн медальт сурагч Болдбаатар онц сурна гэдэг цагийн нарийн хуваарьтай ажиллах, заасан хичээлийг цаг тухайд нь ойлгож авах, ойлгосон зүйлээ дахиж давтаж явдал юм гэж би боддог.

Давтлагыг ганцаарчилж хийхээс нөхөдтэй хамтарт давтаал ашигтай юм шиг санагддаг.

Гэрийн даалгаврыг хийхдээ бичих бодох хичээлээ өдөр, орой унших даалгавраа өглөө, уншвал ойлгогмжтой байдаг юм гэв.

8-ын «А» ангийн онц сурлагатан МПБТЗ-ийн мөнгөн медальт сурагч Должин:

Хичээлийг зөвхөн уншиж давтахаар хязгаарлах биш нөхөдтэй ярьж тайлбарлах буюу асууж ярилцах нь хичээл ойлгох гол арга болдог.

«Онц сурлага бол сурагч хүний хамгийн дээд бахархал байдаг учраас багшийг хичээл зааж байхад анхааралтай сонсож ойлгож авдаг.

Мөн өөртөө ба нөхөдтэй гүн бат мэдлэг үлдээхийн тулд хичээлдүүдээр олон хэлбэрийн маргаан явуулах нь мэдлэгийн хүрээг өргөжүүлэх хамгийн ашигтай арга байдаг гэж ярьв.

ДАВААСҮРЭН

Хаврын шөнийн тэн ха-
г а с хэдийнээ өнгөрч,
нойр гэдэг хулжаад хаа
одсонг бүү мэд.

Амралтаараа хөдөө
гарч ахандаа хэд хонож
ирснээс хойш сэтгэлд
байсхийгээд л хөдөөгийн
тухай бодох боллоо.

Аливаа юмыг бодох
зайлшгүй нэг шалтгаан
байдаг байх.

Би нутгийнхаа шөнийг
л бодсоор байв.

Ганцхан нутгийнхаа шө-
нийг л . . .

Ганц хоёр хоног аятай-
хан шинг амархаа боддоо
миний дүү, ах эгч хоёр
нь болоод л байдаг юм
чинь гэж зэрэг зэрэг үг-
лэвч би зүтгэснээрээ зүт-
гэж төлийн эргүүлд арай
гэж нэг гарах болов.

Тэднийг унтсаны дараа
би үүргэвчнээсээ «Бродү-
вэйн шөнө» хэмээх өгүүл-
лэгийн түүвэр авч хэсэг
уншиж байснаа, бичиж
дуусаагүй байсан найруу-
лалаа үргэлжлүүлэхээр
суув. Гэтэл ах нэг ямаа
нишиглэх шиг боллоо доо
гэв. Би яаран гэрээс га-
рахдаа сэрүүн суугаа би
мэдээгүй байхад унтаа-
гаараа ах, ямаа нишиглэ-
хийг мэдлээ гэж үү гэж
гайхаш төрөн хотон дун-
дуур хэдэнтээ эргэв.

Үнэхээр хашааны тэр-
тээ буланд нэг ямаа
нишиглэхсэн няхл нишиг
тэнцэж босохыг эрмэлзэн
зүтгэж, эх нь нойтон тор-
гон үсий нь дөлоож бай-
лаа. Бат гуайн гэрийн үү-
дээр гэрэл улсхийн нэ-
гэн хүн шуудхан ирэв.

Гэрэлмаа ойртон ирээд
намайг танив бололтой.

—Өө чи гараад ирээ
юу? Ямаа нишиглэхээр нь
та нарыг унтчихаа юм бо-
ловуу гэж бодоод гэснээ.

—Төлчин минь ишгээ
пүнзэнд оруулахгүй бол
даарчина шүү гээд гэрийн
зүг эргэлээ.

Гэрэлмаа бид хоёр уна-
ган багын найзууд.

Уулзаагүй явсаар уд-
жээ. Гэрэлмаа сэтгэл бу-
лаам сайхан хүүхэн бол-
сон байлаа.

Намайг гэрт оруут ах

—Ямар ямаа байна, дар-
гай эвэртэй цагаан ямаа
юу гэв.

—Тиймээ
—Ихэрлээ биз
—Тэглээ

—Тэгнээ тэр гэснээ чи-
мээ ч үгүй унтаад өглөө.

Би ахын хэлсэнд бүр
гайхаж билээ.

—Даргай эвэртэй ца-
гаан ямаа юу, ихэрлээ

биздээ гэнэ үү?

Ах өглөө цайгаа уух
зуураа;

—Өнөө шөнө ч лав гуч
хүрсэн байхаа шөнө дунд

өнгөртөл Гэрэлмаа л ишиг
авч дежур хийх шиг бол-
лоо. Түүнээс хойш Бат

гуай гарсан байх аа гэв.

Яахаараа ах хэдэн ямаа
нишиглэсэн хэн гарч ишиг

авч байгааг хүртэл мэд-
дэг байнаа гэж бодож

суулаа.

Тэгээд морьдоо барих
санаатай хазаар автал;

—Хув цагаан чинь шө-
нө дундын үед л ишиг-
лэнэ билээ дээ.

Гурван ихэр байхаа гэв.

Энэ үг нурууруу минь
хүйтэн ус асгах шиг са-
нагдав. Би гайхалдаа;

—Юу? урьд шөнө ганц
ч ямаа ишиглээгүй шүү

дээ. Би ёстой унтаагүй
гэхэд ах;

—Миний дүүг Гэрэлмаа
ч ганц сайн дөнгөсөн

байхаа, лав л хорь хүр-
сэн. Гэрэлмаа л ирж ав-
чихаад байна билээ гэв.

Ахыгаа ганц сайн ам-
рааж ач тус болохсон гэж
бодсон минь ингэж та-
лаар өнгөрөв.

Би Гэрэлмаагаас хорон-
доо хариугаа авахаар

шийдэв.

Тэгээд ах эгч хоёрыг
унтгал нь ном уншиж бай-
гаад, дулаан хувцас өм-
сөн гадаа гарлаа.

Ямаа ишиглэвэл Гэрэл-

Тэгээд нэрлэхэдээ;
—Аа зогил жаахан дуг
хийчихэж гэж өгүүлэн гэр

рүүгээ явлаа.

Гэрэлмаа нээд алдаж;
—Хариугаа сүүлд аваа-

рай гэв.

Би нэгэнт буцах
болж байгаа тул ах минь

намайг төлийн эргүүлд
гаргасангүй.

Өнгөрсөн хэд хоногийн
явдлыг бодон өөртөө хар-

рамсанаа Гэрэлмаад аль
муугаа мэдэгдэж бүтэл-

гүйтсэн минь миний сэт-
гэлийг их зовоож байв.

Шөнө ч нойр хүрэхгүй
хотонд ямаад шир шир

хивэх нь тодхон сонсог-
доно. Морь минь гэрийн

зүүгээр хойшоо өнгөрч
байгаа бололтой хаана

нэг туриглана.

Хотонд нэг ямаа ишиг-
лэх шиг болов.

Нялх ишигний царгаа
дуу сонсогдож, эх нь

зөөлөн зөөлөн сүжрэн
майлана.

Ах босч гэрээсээ гар-
лаа. Одоо л надад бүх

юм ойлгогдож байв.

Цаг ямагт сэрүүн сэр-
гэлэн байж чадвал бүх

юмыг ах ишгээ мэдэж
болох юм шиг санагдана.

Нойрыг унтаж бардаг-
гүй, сэрж бардаг юм гэж

аавын минь хэлдэг үг са-
наанд буув.

Тооноор сарны тунга-
лаг туяа тусч, хайлмагт-

сан цасны чийглэг сайхан
үнэр анхилна.

Малчин хүн унтах ной-
рондоо ч малаа малла-

саар байдаг ахын эрд-
мийн учрыг би ингэж мэд-

сэн юм.

Эгч минь тогоо шана-
гаа амраалгүй ажилла-

ах үүднийхээ махыг зад-
лан жаал юм боож, би

элдэв юм хэрэггүй, ачаа
тээшний нэмэр гэж хич-

нээн учирлаач тэд минь
халгаасангүй.

Тэгсээр байгаад бид
гурав оройтож унтлаа.

Намайг зүүрмэгдэх гэж
байтал нэг ямаа ишиглэв.

Би хувцасаа бушуухан
өмсөөд гэрээс гарлаа.

Гэрэлмаа бид хоёр дөн-
гөж сая гарсан нялхамьт-

ны дэргэд яг зэрэг
уулзаа.

Тэгээд би Гэрэлмаад:

—Чамаас хариугаа авч
чадахгүй нь ээ гэв.

Гэрэлмаа:

—Чи маргааш буцна
биз дээ гэж огт өөр юм

асуув.

—Тэгнээ

—Үзэгдээд л өнгөрөх
юумаа чи

—Тийм л боллоо доо.

Би өглөө ямаагаа да-
гаад л явчихана.

Уулзаж чадахгүй байх
гээд гараа өгөв.

Би түүний дулаа бут-
рах энхрий гарыг алган

дотроо хэдэнтээ бөмбө-
рүүлсэнээ;

—Гэрэлмаа! Чи жаахан
байхдаа надад юу гэж

хэлдэг байлаа гэхэд;

—За яришгадаа гээд
ичингүйрэн гэрүүгээ

гүйчхэв.

Бид хоёр гэр гэртээ
ортол хэн хэнийгээ эр-

гэж харсаар л явлаа.

Амралтаараа хөдөө гарч
ахандаа хэд хонож ир-

снээс хойш сэтгэл гэдэг
хөдөөгийн тухай л бодох

боллоо.

Аливаа юмыг бодох
зайлшгүй нэг шалтгаан

байдаг байх.

Хаврын налгар дулаан
өдрүүд хүний сэтгэлийн

торгон утсыг доргион
чинчүүлж, хүсэл тэмүүл-

лийн хязгааргүйд даллан
дуудах увидастай юуу

даа.

Би-нутгийнхаа шөнийг
л бодсоор байв.

Ганцхан нутгийнхаа
шөнийг л . . .

Д. РЕНЧИНДОРЖ

НУТГИЙН ШӨНӨ

Өгүүлэл

морь чинь энэ хойт жал-
ганд л байгаа болов уу
гэв.

—Үгүй байлгүй. Би
үдэш урагш нь нилээд

лавхан гаргаад тавьчих-
сан шүү дээ гэхэд;

—Шөнө хойшоо гараад
л явчихана билээ гэнэ.

—Ахын үгэнд орж гэр-
рээс хойш явтал хоёр

морь тэрүүхэн нугачаанд
хоножээ.

Ахыгаа ганц сайн ам-
раага гэж бодоод би да-

раачийн шөнө төлийн эр-
гүүлд гарлаа.

Ном ч уншсангүй. хо-
тоо эргэсээр байгаад үүр

цайлгав.

Юм гэдэг хяслантай
шүү. Би тэр шөнө тавь

жар хүрч ишиглээсэй гэж
бодсон чинь ганц ч ямаа

нишиглэсэнгүй.

Харин ах минь сэтгэл
зовох юмгүй ганц шөнө ч

болов амарч хоносон байх
гэж бодож байлаа.

Өглөө цайгаа ууж суух-

даа ах эгчид хандаж:

маагаас урьтаж авах са-
наатай яг хотон дотроо

суугаад л байв.

Ердөө ч ямаа ишиглэ-
сэнгүй.

Сүүл сүүлдээ залхуу
хүрч эхлээ.

Нэг ямаа долоон! ихэр
ишиг гаргахаар нь бушуу-

хан гэртээ авч ороод л
ахад хэлэх гэсэн чинь

амьсгаа бөглөрчихөөд юу
ч хэлж чадахгүй баахан

зогсов.

Үнэхээр амьсгаа минь
бөглөрчээ.

Би муухай орилон сэр-
вэл Гэрэлмаа;

—Төлчин гуай сайхан
нойрсов уу гээд хамрыг

минь чимчихсэн сууж
байв. Би Гэрэлмаагаас

зовсон гэдэг туйлдаа
хүрэв.

Далхын Магсар

Ардын хувьсгалын партизан,
БНМАУ-ын хувьсгалт тэмцлийн ахмад

зүтгэлтэн, МАХН-ын 1921 оны гишүүн,
Далхын Магсар хүндээр өвчилж бай-

гаад энэ оны 4 дүгээр сарын 21-нд нас
барав. Д. Магсар Дорнод аймгийн

Гурван загал суманд малчин ардын
гэр бүлд төрж, бага залуу насандаа

мал маллан амьдарч байгаад 1921 онд
ардын журамт цэрэгт элсэж, Г. Бум-

цэндийн удирдсан отрядын бүрэлдэ-
хүүнд оролцон, цагааны дээрэмчидтэй

байлдаж явжээ.

Д. Магсар 1921—1936 онд цэрэг,
дотоодыг хамгаалах газар цэргийн

дунд ба ахлах тушаалын даргын ажил
хийжээ. Д. Магсар цэргийн албанаас

халагдсаныхаа дараа сум, баг, брига-
дад даргаар олон жил ажиллаж бай-

гаад сүүлийн жилүүдэд суурийн ах-
лагч, малчнаар ажиллаж байв.

Д. Магсар, МАХН-ын VI, XVI их
хурлуудад төлөөлөгчөөр сонгогдон

оролцож байсан ба нам улсаас түүний

гавъяа зүтгэлийг үнэлэн, МАХН-ын
Төв Хорооны хүндэт үнэмлэх, ойн ме-
далиудаар шагнажээ.

Д. Магсарын зүтгэл чармайлт, нө-
хөрсөг бөгөөд ажилсаг зан чанар бид
бүхэнд үүрд дурсагдана.


Хайрт нөхрөө алдсан явдалд харам-
сан гашуудаж, түүний гэр бүл, төрөл

төрөгсдөд гүн эмгэнэл илэрхийлье.

Ц.АДЪЯА
Ц.ЖАМСРАН
Х.БИЛГЭЭ
Д.ГОНЧИГ
АДАВААНЫМ
Д.ДАМБАЖАМЦ
Д.СУНДУЙ
Я.ДАМДИНСҮРЭН
Ч.ДАШДЭМБЭЭРЭЛ
Р.ЧИМЭДЦЭРЭН
Н.ШАГДАРДАГВА
Б.НАМСРАЙЖАВ
Х.ДАМДИН
Г.ШАРАВ
П.ЖАНЧИВ
Г.ЖАЛБАА
Г.ЖАМБАЛ

Хариуцлагатай эрхлэгч

Д.ТОВУУ



Зөвлөлт Туркменийн Красноводскийн районд тэн-
гэсийн усыг шүүж ариутгах орчин үеийн хүчит то-
ног төхөөрөмж бүхий томоохон хэмжээний усан сан
ажиглалтайд орлоо.

Зураг дээр: Тус усан сангийн хлээг.

ТАСС-ын гэрэл зураг